



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/98/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 99029193
Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 99035990
Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК
Захирал: А.Сарангэрэл
Утас: 9988 4842
Цахим хаяг: gereltekhburtgelaudit01@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Төлбөрийн акт.....	16
4.2 Албан шаардлага.....	17
4.3 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

№ Д.Д. 02.25 № 22
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.НАНДИНЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	98,422,997.36	97,847,889.36
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31120	Гадаад валют	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	98,422,997.36	97,847,889.36
351	Түүхий эд материал	-	2,286,253.00
35110	Тусгай зориулалттай материал	-	2,286,253.00
354	Хангамжийн материал	67,712,997.36	64,851,636.36
35420	Аж ахуйн материал	50,739,696.36	49,328,335.36
35440	Түлш, шатах тослох материал	1,850,000.00	400,000.00
35470	Бусад хангамжийн материал	15,123,301.00	15,123,301.00
35600	Мал амьтад	30,710,000.00	30,710,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	988,589,821.96	936,995,723.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	988,589,821.96	912,419,723.10
392	Биет хөрөнгө	964,013,821.96	912,419,723.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	917,849,459.60	917,849,459.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(73,542,610.03)	(104,475,438.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	13,500,000.00	13,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,500,000.00)	(13,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	259,020,217.60	161,517,531.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(229,017,190.82)	(144,823,560.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131,234,422.26	84,822,178.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	(105,693,026.77)	(64,012,703.51)
39214	Бусад үндсэн хөрөнгө	87,700,000.00	87,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(28,199,999.88)	(36,699,999.84)
93217	Номын фонд	4,662,550.00	10,542,255.99
393	Биет бус хөрөнгө	24,576,000.00	24,576,000.00
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хасагдуулга	(825,000.00)	(825,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	24,576,000.00	24,576,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,087,012,819.32	1,034,843,612.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,329,500.00	14,577,203.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,329,500.00	14,577,203.00
413	Өглөг	9,329,500.00	14,577,203.00
4136	Бусад өглөг	9,329,500.00	14,577,203.00
41361	Байгууллагад төлөх өглөг	9,329,500.00	14,577,203.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,077,683,319.32	1,020,266,409.46
51	Засгийн газрын хувь оролцоо	1,077,683,319.32	1,020,266,409.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	652,793,561.00	652,793,561.00
51101	Өмч: - төрийн	652,793,561.00	652,793,561.00
512	Хуримтлагдсан үр дүн	(233,800,841.81)	(291,217,751.67)
51210	Өмнөх үеийн үр дүн	(233,800,841.81)	(233,800,841.81)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(57,416,909.86)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	658,690,600.13	658,690,600.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,087,012,819.32	1,034,843,612.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,570,673,294.60	1,560,547,288.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,887,494.60	8,165,958.99
120	Нийтлэг татварын бус орлого	39,887,494.60	8,165,958.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,887,494.60	8,165,958.99
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,340,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	36,547,494.60	8,165,958.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,530,785,800.00	1,552,381,330.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,405,738,800.00	1,422,039,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,405,738,800.00	1,422,039,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,057,000.00	12,103,330.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,605,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,498,330.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,057,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,990,000.00	118,238,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,990,000.00	118,238,700.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	4,000,000.00	-
1330	Төсвийн захирагчдаас	4,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,638,349,867.87	1,617,964,198.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,638,349,867.87	1,617,964,198.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,462,906,313.23	1,466,494,612.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,035,949,455.56	1,071,443,728.43
210101	Үндсэн цалин	722,342,925.07	809,399,634.81
210102	Нэмэгдэл	252,899,825.38	183,640,983.92
210104	Урамшуулал	60,706,705.11	78,403,109.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,644,800.00	139,462,974.96
210201	Тэтгэврийн даатгал	94,958,400.00	99,465,277.25
210202	Тэтгэмжийн даатгал	11,171,600.00	9,999,431.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,937,300.00	7,999,545.46
210204	Ажилгүйдлийн даатгал	2,234,300.00	1,999,886.49
210205	Эрүүл мэндийн даатгал	22,343,200.00	19,998,833.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,543,834.80	119,936,092.00
210301	Гэрэл, цахилгаан	4,022,238.00	5,305,889.00
210302	Түлш, халаалт	107,043,436.80	110,635,803.00
210303	Цэвэр, бохир ус	3,478,160.00	3,994,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,547,974.63	16,832,672.00
210401	Бичиг хэрэг	1,015,600.00	2,796,200.00
210402	Тээвэр, шатахуун	6,337,340.00	1,012,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,102,332.00	1,717,211.00
210404	Ном, хэвлэл	919,700.00	776,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	498,600.00	216,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,741,900.00	7,227,873.00
210408	Бараа материал акталсны зардал	8,932,502.63	3,085,988.00

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	30,629,081.00	36,644,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,601,400.00	1,482,400.00
210502	Хоол, хүнс	27,027,681.00	34,126,340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,035,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,430,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	4,430,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	168,000.00
210702	Дотоод албан томилолт		168,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,291,112.00	11,213,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,291,112.00	11,213,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,870,055.24	65,794,004.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,170,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,599,588.22	1,920,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,100,467.02	63,873,804.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	175,443,554.64	151,469,586.61
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	64,162,506.61
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	64,162,506.61
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,218,725.00	87,307,080.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,431,800.00	2,029,750.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,786,925.00	84,977,330.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	136,224,829.64	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	136,224,829.64	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(67,676,573.27)	(57,416,909.86)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(67,676,573.27)	(57,416,909.86)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	652,793,561.00	489,455,216.74	(166,124,268.54)	976,124,509.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652,793,561.00	489,455,216.74	(166,124,268.54)	976,124,509.20
C07	Тайлант үеийн үр дүн			(67,676,573.27)	(67,676,573.27)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,793,561.00	658,690,600.13	(233,800,841.81)	1,077,683,319.32
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,793,561.00	658,690,600.13	(233,800,841.81)	1,077,683,319.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652,793,561.00	658,690,600.13	(233,800,841.81)	1,077,683,319.32

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D08	Тайлант үеийн үр дүн	-		(57,416,909.86)	(57,416,909.86)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,793,561.00	658,690,600.13	(291,217,751.67)	1,020,266,409.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,530,785,800.00	1,552,381,330.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,530,785,800.00	1,552,381,330.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,405,738,800.00	1,422,039,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,405,738,800.00	1,422,039,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,057,000.00	12,103,330.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,605,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,498,330.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,057,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	118,990,000.00	118,238,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,990,000.00	118,238,700.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	4,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,528,965,800.00	1,545,981,330.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,528,965,800.00	1,545,981,330.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,353,522,245.36	1,394,511,743.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,035,949,455.56	1,071,443,728.43
210101	Үндсэн цалин	722,342,925.07	809,399,634.81
210102	Нэмэгдэл	252,899,825.38	183,640,983.92
210104	Урамшуулал	60,706,705.11	78,403,109.70
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,644,800.00	139,462,974.96
210201	Тэтгэврийн даатгал	94,958,400.00	99,465,277.25
210202	Тэтгэмжийн даатгал	11,171,600.00	9,999,431.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,937,300.00	7,999,545.46
210204	Ажилгүйдлийн даатгал	2,234,300.00	1,999,886.49
210205	Эрүүл мэндийн даатгал	22,343,200.00	19,998,833.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,004,334.80	113,238,389.00
210301	Гэрэл, цахилгаан	4,022,238.00	5,305,889.00
210302	Түлш, халаалт	101,503,936.80	103,938,100.00
210303	Цэвэр, бохир ус	3,478,160.00	3,994,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,677,322.00	13,785,311.00
210401	Бичиг хэрэг	1,015,600.00	2,796,200.00
210402	Тээвэр, шатахуун	6,337,340.00	1,012,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,102,332.00	1,717,211.00
210404	Ном, хэвлэл	919,700.00	776,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	498,600.00	216,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,803,750.00	7,266,500.00

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	32,710,121.00	38,280,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,601,400.00	1,482,400.00
210502	Хоол, хүнс	26,557,721.00	34,126,340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,551,000.00	2,671,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,510,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	4,510,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	168,000.00
210702	Дотоод албан томилолт		168,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,291,112.00	11,213,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,291,112.00	11,213,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,735,100.00	1,920,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,735,100.00	1,920,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	175,443,554.64	151,469,586.61
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	64,162,506.61
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	64,162,506.61
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,218,725.00	87,307,080.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,431,800.00	2,029,750.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,786,925.00	84,977,330.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	136,224,829.64	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	136,224,829.64	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,820,000.00</u>	<u>6,400,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,820,000.00	6,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,820,000.00	6,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,820,000.00	6,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,820,000.00	6,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,820,000.00)</u>	<u>(6,400,000.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,540,278,000.00	1,540,278,000.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,540,278,000.00	1,540,278,000.00	-	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,457,502,500.00	1,389,110,343.39	68,392,156.61	95.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,121,941,700.00	1,071,443,728.43	50,497,971.57	95.50
210101	Үндсэн цалин	869,385,300.00	809,399,634.81	59,985,665.19	93.10
210102	Нэмэгдэл	180,500,800.00	183,640,983.92	(3,140,183.92)	101.74
210104	Урамшуулал	72,055,600.00	78,403,109.70	(6,347,509.70)	108.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,235,500.00	139,462,974.96	8,772,525.04	94.08
210201	Тэтгэврийн даатгал	107,899,400.00	99,465,277.25	8,434,122.75	92.18
210202	Тэтгэмжийн даатгал	10,084,000.00	9,999,431.94	84,568.06	99.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,067,200.00	7,999,545.46	67,654.54	99.16

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	2,016,800.00	1,999,886.49	16,913.51	99.16
210205	Эрүүл мэндийн даатгал	20,168,100.00	19,998,833.82	169,266.18	99.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,238,700.00	113,238,389.00	311.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,305,900.00	5,305,889.00	11.00	100.00
210302	Түлш, халаалт	103,938,300.00	103,938,100.00	200.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	3,994,500.00	3,994,400.00	100.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,428,000.00	13,044,311.00	383,689.00	97.14
210401	Бичиг хэрэг	2,055,200.00	2,055,200.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,012,500.00	1,012,500.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,055,200.00	1,717,211.00	337,989.00	83.55
210404	Ном, хэвлэл	822,100.00	776,400.00	45,700.00	94.44
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	216,500.00	216,500.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,266,500.00	7,266,500.00	-	100.00
2105	Нормативт зардал	45,745,200.00	37,824,740.00	7,920,460.00	82.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,027,600.00	1,027,000.00	600.00	99.94
210502	Хоол, хүнс	42,045,900.00	34,126,340.00	7,919,560.00	81.16
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,671,700.00	2,671,400.00	300.00	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	973,500.00	168,000.00	805,500.00	17.26
210702	Дотоод албан томилолт	973,500.00	168,000.00	805,500.00	17.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	616,500.00	608,000.00	8,500.00	98.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	616,500.00	608,000.00	8,500.00	98.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,323,400.00	8,320,200.00	3,200.00	99.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,323,400.00	8,320,200.00	3,200.00	99.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,775,500.00	151,167,656.61	(68,392,156.61)	182.62
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	64,160,576.61	(64,160,576.61)	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	64,160,576.61	(64,160,576.61)	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,775,500.00	87,007,080.00	(4,231,580.00)	105.11
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,029,800.00	2,029,750.00	50.00	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80,745,700.00	84,977,330.00	(4,231,630.00)	105.24
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,540,278,000.00	1,540,278,000.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,422,039,300.00	1,422,039,300.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,422,039,300.00	1,422,039,300.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	118,238,700.00	118,238,700.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	118,238,700.00	118,238,700.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн	Үзүүлэлт	/Төгрөгөөр/ Тайлант оны
---------------	----------	----------------------------

ангилал		Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,103,330.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,103,330.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,801,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	741,000.00
210401	Бичиг хэрэг	741,000.00
2105	Нормативт зардал	455,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	455,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,605,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,605,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	301,930.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	301,930.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,930.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,930.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,103,330.00
	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,605,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,498,330.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 32,766.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 26,213.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 32,359.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 25,887.4 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 407.7 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
			Б
Бараа материал	98,423.0	97,847.9	(575.1)
Үндсэн хөрөнгө	988,589.8	936,995.7	(51,594.1)
Нийт хөрөнгө	1,087,012.8	1,034,843.6	(52,169.2)
Өр төлбөр	9,329.5	14,577.2	5,247.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,077,683.3	1,020,266.4	(57,416.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,087,012.8	1,034,843.6	(52,169.2)

Бараа материалын дансны үлдэгдэл 97,847.9 мянган төгрөг болж, 575.1 мянган төгрөгөөр буурсан байна. Бараа материалын данс Боловсролын газраас химийн кабинетын лабораторийн хэрэглэгдхүүний 2,286.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталж устгасан 3,085.9 мянган төгрөгийн хөрөнгөөр буурчээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 936,995.7 мянган төгрөг болж, 51,594.1 мянган төгрөгөөр буурсан. Үндсэн хөрөнгийн данс Болосролын газраас үнэ төлбөргүй шилжин ирсэн 5,879.7 мянган төгрөгийн хөрөнгөөр, худалдан авсан 7,400.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, акталж устгасан 150,314.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагджээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлогын дүн өмнөх оноос 10,126.0 мянган төгрөгөөр буурсан. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оны мөн үеэс 28,381.5 мянган төгрөгөөр буурсанаас шалтгаалжээ.

Үндсэн үйл ажиллаганы зардал өмнөх оноос 20,385.7 мянган төгрөгөөр буурсан. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал шилжүүлэг байна. Энэ нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд Чоногол хөгжил хөгжил ОНӨААТҮГ-т өгөх 14,577.2 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгийг бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,600,000.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,600,000.00 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 59,722.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,540,278.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,540,278.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,422,039.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 118,238.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,422,039.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 118,238.7 санхүүжилт авч, нийт 1,540,278.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,540,278.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Боловсролын газраас шагнал урамшуулал, бичиг хэргийн зардлын 1,498.3 мянган төгрөгийн, түрээсийн номны 10,605.0 мянган төгрөгийн, нийт 12,103.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бараа үйлчилгээний зардалд 12,101.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Улсны төсөвт 1.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1,586,899.4 мянган төгрөгийн 33 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,545,217.3 мянган төгрөгийн 23 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын Засгийн газрын хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 43 тогтоолын хэрэгжилтийг шалгахад орон тоо бүтэц нэмээгүй, хөрөнгө бэлтгээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газраас итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,570,285.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 391.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,099.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,559,794.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Төлбөрийн акт

Хөдөлмөрийн чадвар алдалтын акттай 1 ажилтны 1-12 сарын цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцсоноос 391.2 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод

албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.2 Албан шаардлага

Нийт 7 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 10,099.5 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллага нь 14,577.2 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,,” заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж өр төлбөр үүсгэхгүй ажиллах, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан төлж барагдуулах

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 242 ширхэг 70,658.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 1,586,899.4 мянган төгрөгийн 33 мэдээллийг ил тод байршуулахаас 1,545,217.3 мянган төгрөгийн 23 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Цалинг буруу тооцоолон олгосон	1	391.2			1	391.2				
2	Худалдан авалтыг Төлбөрийн цахим системд бүртгээгүй, И баримтаар баталгаажуулаагүй	1	10,099.5					1	10,099.5		
3	Өр төлбөр үүсгэсэн	1	14,577.2							1	14,577.2
4	Хураимтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		4	25,067.9	-	-	1	391.2	1	10,099.5	2	14,577.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	1,545,217.3							1	1,545,217.3
Дүн		1	1,545,217.3	-	-	-	-	-	-	1	1,545,217.3
Нийт дүн		5	1,570,285.2	-	-	1	391.2	1	10,099.5	3	1,559,794.5